



**МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2019 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 19/001

Улаанбаатар хот

Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 дугаар сарын 29-ны өдөр 18:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, 6-р хороо, Новотел Улаанбаатар зочид буудлын хүлээн авалтын танхимд болов.

Хурлын дарга: Өлзийбаярын ГАНЗОРИГ

Хурлын нарийн бичгийн дарга: Зоригтын ОДМАА

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 81

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 5,395,763 ширхэг

Хурлын ирц: 86 хувь буюу дийлэнх олонх.

НЭГ. МЭДЭЭЛЭЛ

Тооллогын комиссын дарга М.Алтайбаатар: “Мандал Даатгал” ХК-ийн ТҮЗ-ийн хурлын шийдвэрээр томилогдсон Тооллогын комиссоос ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийн бүртгэлийг танилцуулав.

Мөн Хурлын зар болон хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хорооны 244 тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын дагуу 2019 оны 3 сарын 29-ны өдрийн дотор брокер, дилерийн компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдийн хурлын материалтай танилцах боломжоор хангаж ажилласан болохыг мэдэгдэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах болсон шалтгаан, хуулийн үндэслэлийг танилцуулж, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулснаар хурал албан ёсоор эхлэв.

ХОЁР. ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1 дүгээр асуудал: Компанийн 2018 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг тайлагнах;

2 дугаар асуудал: Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

3 дугаар асуудал: Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах;

4 дүгээр асуудал: Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;

5 дугаар асуудал: Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг хэлэлцэн батлах;

6 дугаар асуудал: Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн батлах;

1 ДҮГЭЭР АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан

Танилцуулгын гол агуулга: Мандал Даатгал ХК-ийн 2018 оны санхүү, үйл ажиллагааны үр дүнг товч танилцуулав. 2018 оны 3-р улиралд амжилттай IPO хийсэнтэй холбоотой мөнгөн хөрөнгө 108%-р өсч 22.9 тэрбум төгрөгт, эздийн өмч 160%-р өсч 15.6 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт хураамжийн орлого өмнөх оноос 23%-р өсч 27.8 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашиг 251% өсч 3.9 тэрбум төгрөгтэй хаагдсан байна. Даатгалын компанийн үйл ажиллагааны голлох үзүүлэлт болох нийлмэл харьцаа 77%-тай, хохирлын харьцаа 28%-тай гарсан байна.

Санхүүгийн тайлангийн хараат бус аудитыг Дэлхийн хэмжээний франчайз болох Гранд Торнтон аудитын фирм хийсэн байна. Уг аудитлагдсан тайланг санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн болохыг 2019 оны 3-р сарын 19-ний өдөр баталгаажуулсан байна.

Түүнчлэн даатгалын салбарын 2018 оны тоймыг хүргэсэн бөгөөд санхүүгийн үр дүнгээр салбарт эзлэх байр суурийн хувьд Мандал Даатгал нь нийт хураамжийн орлогоор салбартаа 3-т, цэвэр ашгийн хэмжээгээр 1-т, нийт хөрөнгөөр 2-т, мөнгөн хөрөнгөөр 1-т тус тус жагсаж байна.

2 ДУГААР АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг

Танилцуулгын гол агуулга: 2018 он Мандал Даатгал ХК-ийн хувьд амжилттай жил байсан бөгөөд гүйцэтгэх удирдлагын баг төлөвлөсөн зорилгоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэв. Мөн хараат бус аудиторыг томилох, санхүүгийн төлөвлөлт, үр дүнг хянахад ТУЗ-ийн зүгээс онцгой анхаарал хандуулан ажилладаг болохыг дурдсан байна. Түүнчлэн 2018 оны 12 сарын 12-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас томилогдсон ТУЗ нь улирлын хурлаа цаг хугацаанд нь хийж, ТУЗ-ийн дэргэдэх хороодууд сар бүр тогтмол хуралдаж, компанийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байгааг онцолсон байна.

Тэмдэглэл:

1. *Хувьцаа эзэмшигч А.Ууганбаяр:* Нэгт, санхүүгийн тайлангийн сонирхлын зөрчилтэй хэлцэл дээр Голомт Банктай 7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн хийсэн байна. Энэ юуны гүйлгээ вэ? Хоёрт, 5 тэрбум төгрөгийг хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулсан гэсэн, энэ яг юунд хөрөнгө оруулсан бэ? Гуравт, хувьцаа эзэмшигчдийн хувьд хувьцаа

хуваах асуудлыг дэмжихгүй байгаа. Хувьцааг хувааснаар олон жижиг хувьцаа эзэмшигчид орж ирэн, хувьцааны үнэ хэлбэлзэл өндөртэй болох эрсдэлтэй. Түүнчлэн жишээ болгон танилцуулж байсан Говь ХК-ийн хувьцаа хувааснаасаа хойш унасан байгаа. Иймд бусад хувьцаа эзэмшигчдийг энэ асуудал дээр татгалзсан санал өгөхийг уриалж байна.

Гүйцэтгэх захирал Б.Жавхлан: Саналыг хүлээн авлаа. Хувьцаа хуваах асуудал дээр таны саналыг анхаарах болно. Хөрөнгийн зах зээлийн хөрөнгө оруулалтын хувьд компаниудын хувьцааны ханшинд нөлөөлж магадгүй учраас яг ямар хувьцаа, бондод хөрөнгө оруулсныг зарлах боломжгүй байгаа. Олон зарласнаар бол жишээ Түмэн Шувуут ХК-д хөрөнгө оруулсныг мэдэж байгаа байх. Хөрөнгийн зах зээлийн хөрөнгө оруулалтын хувьд Мандал Даатгал 3-5 жилээр хөрөнгө оруулалт хийж байгаа бөгөөд олон жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан, тогтмол ашигтай ажилладаг, сайн компаниудад хөрөнгө оруулах бодлого баримталдаг.

Хурлын дарга Ө.Ганзориг: Голомт банктай хийсэн 7 тэрбум төгрөгийн гүйлгээний талаар тодруулга хийе. Мандал Даатгал Голомтоос гадна Ариг, Улаанбаатар хотын банк, Хаан банк зэрэг хэд хэдэн банктай даатгалын зуучлалаар хамтран ажилладаг бөгөөд энэхүү 7 тэрбум нь Голомт банк Мандалд даатгал зуучилж, зарж өгсөн орлого юм. ТУЗ-ийн зүгээс сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг баталдаг бөгөөд үүнд онцгой анхаарал тавьж ажилладаг.

2. *Хувьцаа эзэмшигч А.Базар:* Голомт банкн дээр 7 тэрбумын борлуулалт хийсэн юм байна. Тэгвэл бусад банкууд дээр ямар байгаа вэ? Зуучлалын шимтгэл нь адилхан уу? Түүнчлэн хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулсан 5 тэрбум төгрөгийн хэдэн хувь нь бонд хэдэн хувь нь хувьцаанд байгааг хэлж болох уу? Мөн гарах төлөвлөгөө ямар байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Б.Жавхлан: Хөрөнгө оруулалтын багцын хувьд 1 тэрбум төгрөг нь энгийн хувьцаанд 4 тэрбум нь бондод байршсан байгаа. Бондын хувьд тогтсон бенчмаркууд байна. Харин хувьцааны хувьд бид том өгөөж харахгүй байгаа. Түмэн Шувуут ХК-д бид 200 саяар орсон, 3 жилийн дараа 400 саяар зараад гарахад болж байна л гэж харж байна. Тэгэхээр хувьцаан дээр 3 жилдээ 2 нугалаад, 5 жилдээ 3 нугалсан байхад бол хангалттай өгөөжөө авсан гэж харна. Голомт банк даатгал зуучлахаас гадна өөрсдөө даатгал худалдаж авдаг тэр дүн энэ 7 тэрбумд мөн орсон байдаг. Голомт банканд бусад банкуудаас илүү давуу тал олгосон зүйл байхгүй, зуучлалын шимтгэл бүх зуучлагч банкнуудын хувьд зах зээлийн дундаж дүнгээр явдаг.

Хурлын дарга Ө.Ганзориг: Нэмж хэлэхэд Голомт бол системийн хувьд Монгол улсын хоёр дахь том банк учраас зөвхөн Мандал Даатгалтай ажилладаггүй, бусад даатгалуудтай мөн хамтарч ажилладаг. Голомт өөрөө бодлогоо гаргаад, түүнд нь Мандал нэгдэж явдаг болохоос Мандалтай тусгай хувь, нөхцөл тохирдоггүй.

3. *Хувьцаа эзэмшигч А.Базар:* Таван богд групп тодорхой хэмжээгээр хувь эзэмшдэг болсон. Даатгалын худалдан авалтаа Мандалаас хийж байгаа юу? Түүнчлэн, Таван богд хөрөнгө оруулсантай холбоотой Хаан банк Мандал Даатгалыг дэмжиж байгаа юу? Энэ асуудал өмнөх хувьцаа эзэмшигчдийн хурал дээр тодорхой бус байсан, одоо илүү ахиц гарсан уу?

Хурлын дарга Ө.Ганзориг: Энэ хурлын хэлэлцэх асуудлын хүрээнд ийм деталь мэдээлэл өгөх нь хууль эрх зүйн боломжтой эсэхийг сайн мэдэхгүй байна. Ерөнхийдөө, Таван богд стратегийн хөрөнгө оруулалт хийхээр болж 5%-иар орох байсан боловч хувь

тэнцүүлэгдэн 5% арай хүрээгүй. Хаан банк болон Таван богд групп даатгалын компанигүй. Өөр даатгалын компанид хөрөнгө оруулалт хийгээгүй. Анх стратегийн хөрөнгө оруулагчаар орж ирэх төлөвлөгөөтэй байсан нь даатгал дээр хамтран ажиллах сонирхолтой байгаагийн илрэл болов уу.

4. *Хувьцаа эзэмшигч Б.Лхагва-Очир:* Оюу Толгой компанийн даатгалыг бичиж эхэлсэн холбоотой хураамжийн орлого нэлээн өссөн гэж ойлгосон. Оюу Толгой даатгалаа өгөхөө больчихвол энэ хураамжийг юугаар нөхөх вэ? Энэ тал дээр төлөвлөгөө байгаа юу?

Гүйцэтгэх захирал Б.Жавхлан: Харилцагчтай байгуулсан гэрээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх нь хориотой байдаг. Одоо өгч буй мэдээллийг Оюу Толгой компаниас зөвшөөрөл авсны үндсэн дээр хүргэж байгаа. Оюу Толгой компанитай 3 чиглэлээр хамтарч ажилладаг. Эхний нь далд уурхайн бүтээн байгуулалтын барилга угсралтын даатгалыг хийдэг бөгөөд хураамж нь шууд давхар даатгал руу гарч явдаг. Хоёрт, уурхайн ерөнхий хариуцлагын даатгал байгаа. Мөн хураамж нь давхар даатгал руу шилждэг. Гуравт, ажилтнуудын гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалыг бичдэг. Дийлэнх хураамж нь давхар даатгал руу шилждэг учраас компанийн санхүүгийн үр дүнд гэнэтийн нөлөө үзүүлэх нь харьцангуй бага, мөн бид эдгээр даатгалын 2016 оноос хойш бичиж байгаа учраас нөлөөллүүдийг нь санхүүгийн үр дүндээ шингээж явдаг байгаа.

3 ДУГААР АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан

Танилцуулгын гол агуулга: Мандал Даатгал ХК-ийн 2019 оны төлөвлөгөөг товч танилцуулав. 2019 онд нийт хөрөнгийг 44.3 тэрбум, мөнгөн хөрөнгийг 28.2 тэрбум, нийт хураамжийн орлогыг 31.3 тэрбум, цэвэр ашгийг 5.5 тэрбум төгрөгт хүргэхээр тус тус төлөвлөсөн байна. 2019 оны нөхөн төлбөрийн нийт зардалд 7.2 тэрбум, үйл ажиллагааны зардалд 7.9 тэрбум төгрөгийг тус тус төсөвлөжээ. Түүнчлэн 2019 оны 1-р улирлын үр дүнгээ товч танилцуулсан бөгөөд 1-р улирлын байдлаар компани 2.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

Тэмдэглэл:

1. *Хувьцаа эзэмшигч А.Базар:* 2019 оны 1 дүгээр улиралд 2 тэрбум төгрөгийг ашигтай ажилласан гэж хэллээ. Өмнөх онтой харьцуулахад компани 1-р улиралд нийт ашгийнхаа хэдэн хувийг ер нь хийдэг вэ?

Гүйцэтгэх захирал Б.Жавхлан: Жил бүр адилгүй байдаг. Өнгөрсөн жил 1-р улиралд нийт ашгийнхаа 30%-ийг олсон бол энэ жил мөн адил гэж харж болохгүй. Энэ жил манайх маркетинг болон борлуулалт дэмжсэн төсөл хөтөлбөрүүдэд анхаарч ажиллаж байгаа, иймээс өнгөрсөн онтой шууд жиших боломжгүй. Он дуустал 2019 оны төлөвлөгөө болох 5.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай гарахад чиглэн ажиллах болно.

2. *Хувьцаа эзэмшигч Б.Бямбаноров:* Даатгалын борлуулалтын аппликэйшн хөгжүүлэх үү? Онлайн даатгал дээр ямар бодлого, журам баримталж байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Б.Жавхлан: Манай борлуулалтаа банкны 250 гаруй салбар цэгүүд, өөрийн 50 гаруй борлуулалтын ажилтнаар дамжуулан хийж байгаа учраас одоогоор даатгалын онлайнаар зарах чиглэл рүү ажил төлөвлөөгүй байгаа. Онлайн

аппликэйшныг илүү нөхөн төлбөр, үйлчилгээний шийдэл болгон ашиглана. 2019 онд дижитал шилжилт хийх төсөл хөтөлбөрүүдийг төлөвлөсөн байгаа, гэхдээ эдгээр нь илүүтэй компанийн суурь чадамжийг сайжруулахад чиглэсэн байгаа.

4 ДҮГЭЭР АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг

Танилцуулгын гол агуулга: Мандал Даатгал ХК-ийн ТУЗ-ийн 2019.02.18-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрээр ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн болохын танилцуулав. Нэгж хувьцаанд 100 төгрөгийн ногдол ашиг олгох бөгөөд нийт 624,301,600.00 төгрөгийн ногдол ашиг хуваарилна. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр гаргасан. Ногдол ашгийг 2019 оны 5 дугаар сарын 1-ээс 31-ний өдрүүдэд “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах байдлаар хуваарилах болохыг мэдэгдэв.

5 ДУГААР АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан

Танилцуулгын гол агуулга: Мандал Даатгал ХК-ийн удирдлага болон ТУЗ-ийн зүгээс хувьцааны үнийг 1:100 хуваах саналыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд дэвшүүлж байгааг танилцуулав. Хувьцааг хувааснаар нэгж хувьцааны үнэ хямд болж жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо нэмэгдэх, хувьцааны арилжааны идэвх нэмэгдэж хөрвөх чадвар сайжрах, арилжааны идэвх сайжирснаар хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хөрөнгө болон компанийн үнэлгээ нэмэгдэх зэрэг давуу талууд бий болно гэсэн хүлээлттэй байгааг дурдав. Хувьцааг 100 хувааснаар нийт гаргасан хувьцааны тоо 6,243,016 ширхэгээс 624,301,600 ширхэг болж, хувьцааны нэрлэсэн үнэ 1,000 төгрөгөөс 10 төгрөг болж өөрчлөгдөнө.

Тэмдэглэл:

1. *Хувьцаа эзэмшигч Б.Намуугэрэл:* Хувьцаа хуваах үйл ажиллагаанд хэр хугацаа зарцуулах вэ?

Мандал Даатгал ХК-ийн эрх зүйн нийцлийн мэргэжилтэн Оюунсайхан: Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гарснаар журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүсэлт гаргадаг. Эдгээр байгууллагууд дээр хэр хурдан шийдвэрлэхээс хувьцаа хуваах үйл ажиллагааны хугацаа хамаардаг байгаа.

6 ДУГААР АСУУДАЛ:

1. Хэлэлцсэн нь:

Танилцуулсан: Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Жавхлан

Танилцуулгын гол агуулга: Хувьцаа хуваахтай холбоотой компанийн дүрэмд орох өөрчлөлтийг танилцуулав. Хувьцаа хувааснаар дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1. дэх заалт “Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны

нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 624,301,600 ширхэг энгийн хувьцаа байна.” гэж өөрчлөгдөнө.

САНАЛ ХУРААЛТ

Танилцуулсан: Тооллогын комиссын дарга А.Алтайбаатар

Танилцуулгын гол агуулга: Санал хураалтын хуудас бөглөх зааварчилгааг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав.

2 ДУГААР АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлахад санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 5,393,509 ширхэг хувьцааны санал буюу 86 хувь нь зөвшөөрсөн санал өгөв.

5 ДУГААР АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн хувьцааг 1:100 хуваах саналыг батлахад санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 5,389,936 ширхэг хувьцааны санал буюу 86 хувь нь зөвшөөрсөн санал өгөв.

6 ДУГААР АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлахад санал өгсөн хувьцаа эзэмшигчдийн 5,391,632 ширхэг хувьцааны санал буюу 86 хувь нь зөвшөөрсөн санал өгөв.

Тооллогын комиссын дарга А.Алтайбаатар: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарч буй тогтоолын төслийг уншиж танилцуулж, хуралд оролцогсдод талархал илэрхийлснээр 20:10 цагт хурал өндөрлөв.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

3.ОДМАА

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

ТАНИЛЦСАН:

Ө.ГАНЗОРИГ

Хурлын дарга

